ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/020/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207,
Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 88883776 Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 233

танай 2025.01.24 -ны № 13 -т

ДОРНОД АЙМГИЙН МАЛ
ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН
ДАРГА Ч.АЮУШМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилго, 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг даргаас 94.6 хувьтай үнэлсэн байна.

011022043

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **392,592,278.08** | **361,637,637.32** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | **8,468,935.02** | **-** |
| **335** | **Бусад авлага** | 8,468,935.02 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 8,468,935.02 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **384,123,343.06** | **361,637,637.32** |
| **351** | **Түүхий эд материал** | 319,854,492.06 | 260,963,927.99 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 165,367,958.00 | 165,367,958.00 |
| 35130 | Эм боох материал | 154,486,534.06 | 95,595,969.99 |
| **354** | **Хангамжийн материал** | 46,188,851.00 | 82,593,709.33 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,987,988.00 | 1,870,388.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 43,960,863.00 | 80,483,321.33 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 240,000.00 | 240,000.00 |
| 35600 | Мал амьтад | 18,080,000.00 | 18,080,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **912,933,886.26** | **1,429,443,497.01** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **912,933,886.26** | **1,429,443,497.01** |
| **392** | **Биет хөрөнгө** | **782,350,886.33** | **1,299,256,497.08** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 567,751,054.00 | 1,001,651,054.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (113,704,702.65) | (135,575,675.85) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 330,089,929.67 | 490,089,929.67 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (212,097,766.25) | (252,379,951.66) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 382,833,411.12 | 421,560,611.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (204,639,567.70) | (252,469,495.98) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 57,737,913.24 | 57,737,913.24 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (25,619,385.10) | (31,357,887.46) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **130,582,999.93** | **130,186,999.93** |
| 39301 | Програм хангамж | 1,980,000.00 | 1,980,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,397,000.07) | (1,793,000.07) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 130,000,000.00 | 130,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,305,526,164.34** | **1,791,081,134.33** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР(IV)** | **8,468,935.02** | **425,100.77** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **8,468,935.02** | **425,100.77** |
| 413 | Өглөг | 8,468,935.02 | 425,100.77 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 198,000.77 |
| 41312 | НДШ-ийн өглөг | - | 62,694.77 |
| 41313 | ХХОАТ-ынөглөг | - | 135,306.00 |
| 41360 | Бусад өглөг | 8,468,935.02 | 227,100.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 227,100.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 8,468,935.02 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,297,057,229.32** | **1,790,656,033.56** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,297,057,229.32** | **1,790,656,033.56** |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 816,933,829.03 | 1,310,532,633.27 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 816,933,829.03 | 816,933,829.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 493,598,804.24 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 480,123,400.29 | 480,123,400.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,305,526,164.34** | **1,791,081,134.33** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| нсны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **8,892,208,708.02** | **5,496,117,910.49** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,661,545,312.02** | **1,668,548,108.49** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,661,545,312.02** | **1,668,548,108.49** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,432,500.00 | 5,859,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,432,500.00 | 5,859,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 31,055,975.85 | 611,942,200.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 1,627,056,836.17 | 1,050,746,908.49 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,230,663,396.00** | **3,827,569,802.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,102,258,000.00** | **1,807,344,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,102,258,000.00 | 1,807,344,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **6,128,405,396.00** | **2,020,225,602.00** |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 446,589,456.00 | 485,519,882.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,681,815,940.00 | 1,534,705,720.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **9,098,273,606.18** | **5,002,519,106.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,098,273,606.18** | **5,002,519,106.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,028,667,106.46 | 4,698,139,633.69 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 830,253,618.11 | 1,146,028,765.74 |
| 210101 | Үндсэн цалин | 475,009,503.11 | 577,167,269.74 |
| 210102 | Нэмэгдэл | 231,234,036.00 | 409,988,108.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,634,014.00 | 30,063,000.00 |
| 210104 | Урамшуулал | 109,376,065.00 | 128,810,388.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **116,479,288.82** | **158,413,187.77** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,520,023.08 | 111,652,487.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,118,767.79 | 11,690,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,890,799.85 | 6,678,759.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,722,698.78 | 5,845,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,226,999.32 | 22,546,640.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,249,993.35** | **21,055,381.70** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,426,438.35 | 12,505,715.70 |
| 210302 | Түлш, халаалт | 4,392,795.00 | 6,650,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,430,760.00 | 1,898,966.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,727,115.48** | **58,781,197.90** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,274,690.00 | 2,810,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,748,100.00 | 26,070,518.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,213,040.00 | 1,926,520.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,160,050.00 | 27,973,359.90 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 6,331,235.48 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **1,772,583,494.23** | **1,191,966,802.33** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,772,583,494.23 | 1,191,966,802.33 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,019,400.00** | **6,850,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,765,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,019,400.00 | 4,085,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,410,000.00** | **38,791,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,410,000.00 | 38,791,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,116,048,483.00** | **1,956,768,029.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,107,298,751.00 | 1,946,416,872.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,695,940.00 | 499,425.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 325,592.00 | 344,332.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 231,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 4,740,000.00 | 7,500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,307,200.00 | 1,303,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **118,895,713.47** | **119,484,869.25** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,721,293.00 | 3,367,280.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 110,174,420.47 | 116,117,589.25 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **69,606,499.72** | **304,379,472.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,160,100.00 | 201,974,900.25 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 4,999,990.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 30,102,458.25 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 166,272,452.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,160,100.00 | 600,000.00 |
| **2134** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 67,446,399.72 | 102,404,572.31 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 67,446,399.72 | 101,609,372.31 |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | - | 795,200.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(206,064,898.16)** | **493,598,804.24** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,070,204.00** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 236,808.00 | |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал | 3,833,396.00 | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)-(5)** | **(210,135,102.16)** | **493,598,804.24** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **7,234,095,896.00** | **3,841,897,737.02** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,432,500.00** | **5,859,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,432,500.00** | **5,859,000.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлго | 3,432,500.00 | 5,859,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | - | . |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,230,663,396.00** | **3,836,038,737.02** |
| 1310 | Улсын төсвөөс | **1,102,258,000.00** | **1,807,344,200.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,102,258,000.00 | 1,807,344,200.00 |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 6,128,405,396.00 | 2,028,694,537.02 |
| **131103** | ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 446,589,456.00 | 493,988,817.02 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,681,815,940.00 | 1,534,705,720.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **7,234,095,896.00** | **3,821,212,737.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,234,095,896.00** | **3,821,212,737.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,164,489,396.28** | **3,516,833,264.46** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 830,253,618.11 | 1,145,666,359.74 |
| 210101 | Үндсэн цалин | 475,009,503.11 | 576,804,863.74 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 231,234,036.00 | 409,988,108.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 14,634,014.00 | 30,063,000.00 |
| 210103 | Урамшуулал | 109,376,065.00 | 128,810,388.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **116,479,288.82** | **158,350,493.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,520,023.08 | 111,589,793.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,118,767.79 | 11,690,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,890,799.85 | 6,678,759.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,722,698.78 | 5,845,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 17,226,999.32 | 22,546,640.20 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **22,249,993.35** | **21,055,381.70** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,426,438.35 | 12,505,715.70 |
| 210302 | Түлш, халаалт | 4,392,795.00 | 6,650,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,430,760.00 | 1,898,966.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **24,904,510.00** | **30,060,620.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,766,500.00 | 2,693,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,748,100.00 | 21,688,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,213,040.00 | 1,926,520.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,176,870.00 | 3,752,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **10,482,460.00** | **16,008,500.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 10,116,460.00 | 16,008,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 366,000.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **17,019,400.00** | **10,665,700.00** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 5,000,000.00 | 2,765,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,019,400.00 | 7,900,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,410,000.00** | **38,791,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,410,000.00 | 38,791,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,122,968,833.00** | **2,095,936,330.02** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,114,219,101.00 | 2,085,585,173.02 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 604,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,695,940.00 | 499,425.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 325,592.00 | 344,332.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 231,000.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 4,740,000.00 | 7,500,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,307,200.00 | 1,303,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **8,721,293.00** | **298,480.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,721,293.00 | 298,480.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **69,606,499.72** | **304,379,472.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,160,100.00 | 201,974,900.25 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 4,999,990.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 30,102,458.25 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 166,272,452.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,160,100.00 | 600,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **67,446,399.72** | **102,404,572.31** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 67,446,399.72 | 101,609,372.31 |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | - | 795,200.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **20,685,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **20,685,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **20,685,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | | **20,685,000.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | | **20,685,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 20,685,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **(20,685,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Үзүүлэлт | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **480,123,400.29** | **816,933,829.03** | **1,297,057,229.32** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | **480,123,400.29** | **816,933,829.03** | **1,297,057,229.32** |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | 493,598,804.24 | 493,598,804.24 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **480,123,400.29** | **1,310,532,633.27** | **1,790,656,033.56** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,808,844,200.00** | **1,711,593,827.69** | 97,250,372.31 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,808,844,200.00** | **1,711,593,827.69** | 97,250,372.31 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,600,013,600.00** | **1,509,618,927.44** | 90,394,672.56 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,139,017,600.00** | **1,055,413,588.74** | 83,604,011.26 |
| 210101 | Үндсэн цалин | 650,738,700.00 | 564,149,411.74 | 86,589,288.26 |
| 210102 | Нэмэгдэл | 342,392,700.00 | 403,160,508.00 | (60,767,808.00) |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 53,253,500.00 | 30,063,000.00 | 23,190,500.00 |
| 210104 | Урамшуулал | 92,632,700.00 | 58,040,669.00 | 34,592,031.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **143,627,300.00** | **143,627,300.00** | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,866,600.00 | 96,866,600.00 | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,690,100.00 | 11,690,100.00 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,845,000.00 | 5,845,000.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,845,200.00 | 5,845,200.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,380,400.00 | 23,380,400.00 | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **25,930,100.00** | **21,055,381.70** | 4,874,718.30 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,728,700.00 | 12,505,715.70 | 4,222,984.30 |
| 210302 | Түлш, халаалт | 6,650,700.00 | 6,650,700.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,550,700.00 | 1,898,966.00 | 651,734.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **28,791,200.00** | **28,772,420.00** | **18,780.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,694,500.00 | 2,693,200.00 | 1,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,400,200.00 | 20,400,200.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн | 1,944,000.00 | 1,926,520.00 | 17,480.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төлбөр | | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,752,500.00 | 3,752,500.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **16,058,500.00** | **16,008,500.00** | **50,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,058,500.00 | 16,008,500.00 | 50,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **28,585,900.00** | **28,585,700.00** | **200.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,685,200.00 | 20,685,000.00 | 200.00 |
| 210602 | Тавилга | | | - |
| 210604 | Урсгал засвар | 7,900,700.00 | 7,900,700.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **28,352,200.00** | **28,271,400.00** | **80,800.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 28,352,200.00 | 28,271,400.00 | 80,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **189,351,400.00** | **187,586,157.00** | 1,765,243.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 177,835,000.00 | 177,235,000.00 | 600,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 604,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 705,700.00 | 499,425.00 | 206,275.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 367,300.00 | 344,332.00 | 22,968.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 132,000.00 | 99,000.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээ | 8,237,600.00 | 7,500,000.00 | 737,600.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,469,000.00 | 1,303,600.00 | 165,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **299,400.00** | **298,480.00** | **920.00** |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 299,400.00 | 298,480.00 | 920.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **208,830,600.00** | **201,974,900.25** | **6,855,699.75** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 208,830,600.00 | 201,974,900.25 | 6,855,699.75 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 5,000,000.00 | 4,999,990.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,984,500.00 | 30,102,458.25 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 171,236,800.00 | 166,272,452.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 609,300.00 | 600,000.00 | 9,300.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,807,344,200.00 | **1,711,593,827.69** | - |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,807,344,200.00 | **1,711,593,827.69** | - |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,807,344,200.00 | **1,711,593,827.69** | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,027,899,337.02** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,027,899,337.02** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,027,899,337.02 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 90,252,771.00 |
| 210101 | Үндсэн цалин | 12,655,452.00 |
| 210102 | Нэмэгдэл | 6,827,600.00 |
| 210104 | Урамшуулал | 70,769,719.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 14,723,193.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,723,193.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,288,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,288,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,765,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,765,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,520,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,520,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,908,350,173.02 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,908,350,173.02 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,028,694,537.02** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **2,028,694,537.02** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 493,988,817.02 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,534,705,720.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1.5 сая төгрөгийн алдаа[1] илэрсэнд 1.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов

### 2.1 Төлбөрийн акт:

Нягтлан бодогчид үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг улирлын үр дүнгийн урамшууллын гүйлгээг 2 удаа давхардуулан 1.5 сая төгрөгийг олгосон нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Нягтлан бодогчид үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг улирлын үр дүнгийн урамшууллын гүйлгээг 2 удаа давхардуулан олгосон | 1 | 1,471.0 | 1 | 1,471.0 | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **1,471.0** | **1** | **1,471.0** | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 2 гүйлгээний мэдээллийг ил тод байршуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| **Нийт дүн** | **1** | **-** | | | | | **1** | **-** |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр Дугаар 44/1912 5199 DEA-2025/1620/НА-СТА-ТШЗ Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газарт ажиллаж байсан ажилтанд цалин хөлсийг 1,471,000.00 төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалын хавсралт "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 4.1.5-д "Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үндэслэн батлагдсан төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж, төрийн өмч, төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлэх" гэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "*цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" шаардлагыг хангахгүй болон илүү олгосон 1,471,000.00 /нэг сая дөрвөн зуун далан нэгэн мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2125050204

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Ч.Аюушмаа, нягтлан бодогч Э.Цэвээнжав нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

"ХААН КОНСАЛТИНГ АУДИТ" ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э.НАНДИНЧИМЭГ